


ӨВЛИЙН УЛИРЛЫН ЦАГ АГААР, УУР АМЬСГАЛЫН ОНЦЛОГ

Монгол орны өвлийн улирал 12 дугаар сараас 2 дугаар сард үргэлжлэх ба энэ хугацаанд агаар, хөрсний температур эрс багасаж их хүйтрэх, цас орох, цасан бүрхүүл тогтох, цасан шуурга шуурах, их цас унах, манан татах, том хот суурин газарт хүний хүчин зүйлийн нөлөөгөөр өтгөн утаа тогтох зэрэг үзэгдэл ажиглагддаг онцлогтой.

Монгол оронд агаарын хамгийн бага температур Идэр, Тэс, Завхан голын хөндий, Увс, Дархадын хотгороор -50°C , Алтайн өвөр говь, Говийн нутгийн өмнөд хэсгээр -35°C , бусад нутгаар -40°C -ээс доош бууж хүйтрэхийг “Их хүйтэн” гэж үзнэ. Уур амьсгалын өөрчлөлтөөс (Зураг-1. 1940-2021 оны мэдээгээр газар орчмын агаарын температур $0.04^{\circ}\text{C}/\text{жил}$ -ээр дулаарсан) үүдэн Монгол орны ихэнх нутгийг хамарч удаан хугацаагаар их хүйтэн өвөл болох нь цөөрч байгаа боловч 1 дүгээр сард их хүйтрэлт цөөнгүй давтагдаж байна.




Зураг-1. Өвлийн улирлын агаарын дундаж температур

Жилийн хамгийн хүйтэн 1 дүгээр сарын дундаж температур Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулс хоорондын хөндийд $-30\text{...}-34^{\circ}\text{C}$, өндөр уулс, тэдгээрийн хоорондох хөндийгөөр $-25\text{...}-30^{\circ}\text{C}$, талархаг нутагтаа $-20\text{...}-25^{\circ}\text{C}$, говь цөлийн бүсээр $-15\text{...}-20^{\circ}\text{C}$, өмнөд говиор -15°C -аас -12°C хүйтэн байдаг. 1940-өөд оноос хойш хийсэн цаг уурын хэмжилтийн мэдээгээр агаарын үнэмлэхүй бага температур -55.3°C (1976 оны 12 дугаар сард Увс аймгийн Зүүнговь суманд) хүрч байсан бол нийслэл Улаанбаатарт -49.0°C хүрч (1954 оны XII сард) хүйтэрч байжээ.

Жилийн хүйтэн улирлын температурын горимд инверсийн нөлөө их. Тэгш тал хээр газарт газрын гадаргаас дээшлэх тутам агаарын дундаж температур буурдаг зүй тогтолтой бол зарим газар температур өндрөөсөө нэмэгдэхийг инверсийн үзэгдэл гэдэг. Томоохон голуудын хөндийд байрладаг аэрологийн станцуудын мэдээгээр жилийн хүйтэн улиралд бараг өдөр бүр шахам 600-1000 м орчим зузаантай $6\text{-}17^{\circ}\text{C}$ -ийн эрчимтэй газар орчмын температурын инверс тогтоно. Үүнээс болж голын хөндий, хотгор газарт 100 м өндөрсөх тутам агаарын температур $0.8\text{-}0.9^{\circ}\text{C}$ -аар, уулын хажуу, тал газарт 0.6°C -аар дулаарна.

Жилийн хүйтэн улиралд говь цөлийн бүсэд 10мм орчим, уулархаг орон нутаг, Увс нуурын хотгорт 20...30мм, бусад нутагт 10...20мм цас орно. Алтай, Хангай, Хэнтий, Хөвсгөлийн уулсаар 150 хоногоос дээш, хээрийн болон ойт хээрийн бүсэд 100...150 хоног, Их нууруудын хотгор, Дорнод Монголын тал, хээрийн бүсэд 50...100 хоног, говь цөлийн бүсэд 50 хоногоос цөөн хоног цасан бүрхүүл тогтоно. Цасан бүрхүүлийн зузаан их биш уулархаг нутагт дунджаар 5см, хамгийн зузаан цасны дундаж 30см-ээс их, хээрийн бүсэд дунджаар 2...5см, хамгийн их цасны дундаж зузаан 15...20см байна. Говийн бүсэд цас тогтохгүй жил

олонтаа тохиолдоно. Цасан бүрхүүл нь нарны цацрагийн 90% ойлгож, нил улаан туяаг өөртөө шингээж, өөрөө бараг туйлын хар биет болно. Монгол оронд цасны нягт өвлийн эхээр 0.12...0.14г/см³ байснаа аажмаар нэмэгдсээр 0.20...0.22г/см³ хүрнэ.



Цасан шуурга. Нийгмийн төрөл бүрийн салбар, аж ахуйн үйл ажиллагаанд зохисгүй нөлөөлөл үзүүлдэг цаг агаарын нэг аюултай үзэгдэл нь цасан шуурга юм. Цасан шуургыг орон шуурах, нам цасан шуурга, явган шуурга гэж ялгадаг. **Орон шуурах (SN BLSN)** гэдэг нь үүлнээс цас орж, хүчтэй салхины нөлөөгөөр шуурч байгаа үзэгдэл юм. Энэ үед газрын гадаргаас цас салхинд хийсэж байгаа эсэхийг ялгахад бэрх болно. **Нам цасан шуурга (BLSN)** нь газрын гадарга дээрх цас хүчтэй салхины нөлөөгөөр хийсэх үзэгдэл юм. Энэ үед хийсэж буй цас нэлээд өндөрт, хүний нурууны өндрөөс дээш гарч, алсын барааны харагдацыг муутгана. **Явган шуурга (DRSN)** гэдэг нь газар дээрх цас газрын гадаргын дагуу салхины нөлөөгөөр хийсэх үзэгдэл юм.

Монгол оронд цасан шуургатай өдрийн тоо дундажаар 1-12, ялангуяа Дорнод хязгаарт, Эрдэнэцагаан орчимд хамгийн олон, 19 хүрэх ба арван нэг, гуравдугаар сард хамгийн олон тохиолдоно. Орон шуургатай өдрийн тооны газарзүйн тархацад их утгын гурван муж илэрдэг бөгөөд нэг дэх нь Архангай, Өвөрхангай, Төв, Дундговь аймгийн зааг нутгаар (төвийн нутгийн баруун өмнөд хэсэг) жилд 5 өдрөөс олон, үүний дотор Эрдэнэсант, Хужирт орчим 9.7...10.3 өдөр хүрнэ. Хоёр дахь их утгын муж нь тус орны зүүн хэсэгт Сүхбаатар аймгийн нутгаар жилд дундажаар 6 өдрөөс олон байгаа нь энэ нутгийг циклоны гол замнал дайрч гарч байгаагаар тайлбарлагдана. Гурав дахь их утгын муж Алтай орчим 9.3 өдөр хүрдэг нь энэ бүс нутаг өндөрлөг, салхи ихтэй байдагтай холбоотой.

Нам шуурганы газарзүйн тархацыг авч үзвэл Сүхбаатар аймгийн нутаг, Дорнод аймгийн өмнөд хэсгээр жилд 5 өдрөөс олон, Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай аймгийн нутгаар давтагдал нь арай их, үүний дотор Хужиртад 5.4, Баянхонгорт 6.1 өдөр хүрнэ. Алтайн цаад говийн нутгаар жилд 1.0 өдөр, Их нууруудын хотгороор арван жилд 1.0...2.0 өдөр болно.

Явган шуургатай өдрийн тоо олон жилийн дундаж байдлаар Ховдод 0.4 өдөр, Эрдэнэцагаанд 28.5 өдөр хүртэл хэлбэлзэнэ. Явган шуурга нь Архангай, Өвөрхангай, Төв, Дундговь, Булган аймгийн зааг, Говь-Алтай аймгийн уулархаг нутаг, Хэнтий аймгийн зүүн хойд хэсгээр жилд 10...20 өдөр, тэгвэл Увс аймгийн Ханхөхийн нуруу, Хөвсгөл нуур, Арцын өвөр хоолойд орчноосоо 2-3 дахин их, харин Алтайн цаад говь, Өмнөговь аймгийн өмнөд хэсэг, Ир нууруудын хотгор, Хөвсгөлийн уулс, Сэлэнгэ аймгийн нутгаар жилд 5 хоногоос цөөн шуурна.

Орон шуурганы үргэлжлэх хугацаа мөн орон шуургатай өдрийн тоотой адил нэлээд хэлбэлзэлтэй, 50...95 цаг хүртэл байна. Харин тасралтгүй үргэлжлэх хугацааг цагийн зайцаар авч үзвэл 30...40% нь 1.1...3.0 цагийн хооронд оногдох ба 30 минутаас богино, 12 цагаас их хугацаагаар удаан үргэлжлэх орон шуурга цөөн тохиолдоно. Тухайлбал: Буянт-Ухаа станцын мэдээгээр орон шуурга нь 0.0...15 минут үргэлжлэх нь 10.5%, 15.1-30.0 минут- 9.8%, 30.1 минутаас 1.0 цаг-15.4%, 1.1...3.0 цаг-35.0%, 3.1...6.0 цаг-18.7%, 6.1...9.0 цаг-5.7%, 9.1...12.0 цаг 1.6%, 12.1...15.0 цаг 3.2% байна.

Эх сурвалж: Ус Цаг Уур, Орчны Судалгаа, Мэдээллийн Хүрээлэн
<http://119.40.97.103/climateservice/>